ЭРҮҮЛ МЭНДИЙН АЖИЛТНЫ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

НЭГ. ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ БОЛСОН ҮНДЭСЛЭЛ, ШААРДЛАГА

Монгол Улсын иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхтэй. Эрүүл мэндийн салбарт ажиллагсад нь тус үндсэн эрхийг бодит амьдрал дээр хэрэгжүүлэгч гол “хүний нөөц” бөгөөд тэдний хөдөлмөрийн нөхцөл, мэргэжлийн үйл ажиллагааны баталгаа, ёс зүй, хариуцлага, эрсдэлийн удирдлагын тогтолцоо хангагдаагүй тохиолдолд иргэн эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлаар тогтвортой хангагдах нөхцөл алдагдах эрсдэлтэй.

Сүүлийн жилүүдэд эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн төвлөрөл, хот хөдөөгийн тэнцвэргүй байдал, ажлын ачаалал, сэтгэлзүйн дарамт, мэргэжлийн маргаан, хариуцлагын эрсдэл, үйлчлүүлэгчийн зүй бус харьцаа, цахим орчинд нэр төрд халдах, хууль бус дүрс/дуу бичлэг нийтлэх зэрэг асуудал бодитоор нэмэгдэж, “эрүүл мэндийн ажилтны эрх зүйн хамгаалал” нь зөвхөн хөдөлмөрийн харилцааны хүрээнээс давсан, салбарын чанар–аюулгүй байдлын үндсэн нөхцөл болж байна.

Өнөөдрийн байдлаар нийт 4,914 гаруй эрүүл мэндийн байгууллага үйл ажиллагаа явуулж, 69.7 мянга орчим эрүүл мэндийн ажилтан хүн амын эрүүл мэндийг хамгаалах үйлсэд ажиллаж байгаа бөгөөд хүний нөөцийн тоон үзүүлэлтээс үл хамааран хүртээмж, жигд хуваарилалт, тогтвортой ажиллах нөхцөл, мэргэжлийн хөгжлийн бодит баталгаа нь салбарын үр ашиг, үйлчилгээний чанарт шууд нөлөөлж байна. Иймээс эрүүл мэндийн ажилтны эрх зүйн байдлыг бие даасан хуульд цогцоор нь зохицуулж, хүний нөөцийн төлөвлөлт–менежмент, ажлын байрны аюулгүй байдал, мэргэжлийн ур чадварын баталгаа, ёс зүй, өөрөө удирдах байгууллага, мэргэжлийн хариуцлагын даатгал, маргаан шийдвэрлэх дэг журам зэрэг институцийн зохицуулалтыг нэг мөр ойлгомжтой болгох шаардлага үүсэж байна.

Энэхүү шаардлага нь улсын урт, дунд хугацааны бодлого, салбарын шинэчлэлийн зорилт, хүний нөөцийн тогтвортой байдлыг нэмэгдүүлэх чиглэлтэй уялдахын зэрэгцээ “эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах” үндсэн зорилготой шууд холбоотой юм.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА, ХАМРАХ ХҮРЭЭ

“Эрүүл мэндийн ажилтны тухай” хуулийн төслийн зорилго нь эрүүл мэндийн ажилтны эрх зүйн байдлыг бие даасан байдлаар тодорхойлж, тэдний мэргэжлийн үйл

ажиллагааг аюулгүй, тасралтгүй, хараат бус хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Түүнчлэн эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулах, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах, мэргэжлийн ур чадвар, ёс зүй, хариуцлагын зохистой тогтолцоог бүрдүүлэх замаар иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэхүү хуулийн төсөл нь эрүүл мэндийн салбарт ажиллагсдын эрх зүйн байдлыг цогцоор нь зохицуулах зорилгоор дараах үндсэн харилцааг хамруулна. Үүнд эрүүл мэндийн ажилтны нийтлэг эрх, үүрэг, нийгмийн баталгаа, хөдөлмөрийн онцлог нөхцөлтэй холбоотой харилцаа, түүнчлэн хүний нөөцийн төлөвлөлт, бүртгэл, мэдээлэл, тайлагнал, үнэлгээ, ажиллах орчны аюулгүй байдал, ажлын ачааллыг зохистой түвшинд барих зохицуулалт хамаарна.

Мөн эмнэлгийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх шалгалт, зөвшөөрөл (лиценз)-ийн тогтолцоо, төгсөлтийн дараах болон тасралтгүй сургалтын эрх зүйн үндэс, мэргэжлийн ёс зүй, стандарт, эмнэлгийн мэргэжилтний өөрөө удирдах байгууллагын эрх зүйн байдалтай холбоотой харилцааг зохицуулна. Үүний зэрэгцээ эмнэлгийн тусламж, үйлчилгээний явцад үүсэх эрсдэлийн удирдлага, мэргэжлийн хариуцлагын даатгалын тогтолцоо, эмнэлгийн маргаан, гомдлыг шүүхийн болон шүүхийн бус журмаар шийдвэрлэх, мэргэжлийн дүгнэлт гаргах, маргаанд оролцогч талуудын эрх, ашиг сонирхлыг тэнцвэртэй хангах дэг журам, түүнчлэн хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, шилжилтийн зохицуулалт зэрэг харилцааг энэхүү хуулиар цогцоор нь зохицуулна.

Энэхүү хуулийн төсөл нь улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад ажиллаж буй эрүүл мэндийн ажилтанд хамаарах бөгөөд үүнд эмнэлгийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч эмч, сувилагч, эх баригч, эм зүйч, сэргээн засах чиглэлийн мэргэжилтэн зэрэг эмнэлгийн мэргэжилтэн, түүнчлэн эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих чиг үүрэг бүхий бусад ажилтны эрх зүйн байдлыг хамруулна.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ БҮТЭЦ, БҮЛЭГ ТУС БҮРЭЭР ЗОХИЦУУЛСАН АГУУЛГА

Энэхүү хуулийн төсөл нь нийт 9 бүлэг, 90 зүйлтэй бөгөөд эрүүл мэндийн ажилтны эрх зүйн байдлыг бие даасан байдлаар тодорхойлох, тэдний мэргэжлийн үйл ажиллагааг тогтвортой, аюулгүй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор бүлэг тус бүрээр дараах үндсэн харилцааг зохицуулж байна.

Нэгдүгээр бүлэг (Нийтлэг үндэслэл)-т хуулийн зорилго, үйлчлэх хүрээ, нэр томьёоны тодорхойлолт, эрүүл мэндийн ажилтны үйл ажиллагаанд баримтлах үндсэн

зарчим, суурь ойлголтыг тодорхойлсон. Нэгдүгээр бүлгийн зохицуулалт нь хуулийн нийт бүтэц, агуулгын суурь хүрээг тогтоож, дараагийн бүлгүүдэд хэрэглэгдэх ухагдахуун, ойлголтыг нэг мөр ойлгож хэрэглэх эрх зүйн үндэс болдог.

Хоёрдугаар бүлэг (Эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн удирдлага, ажиллах орчин)-т улсын болон орон нутгийн түвшинд эрүүл мэндийн ажилтны хүний нөөцийн төлөвлөлт, хэрэгцээ–хангамжийн тооцоолол, бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, тайлагнал, үнэлгээтэй холбоотой харилцааг зохицуулсан. Түүнчлэн байгууллагын түвшинд ажлын байрны эрсдэлийн үнэлгээ, хөдөлмөрийн аюулгүй байдал, ажлын ачааллыг зохистой түвшинд барих, хамгаалах хэрэгсэл, сургалтын дэмжлэгтэй холбоотой асуудлыг тусгасан. Ингэснээр хот, хөдөөгийн хүний нөөцийн тэнцвэргүй байдал, алслагдсан бүс нутагт ажиллах нөхцөлийг бодлогын болон зохион байгуулалтын арга хэрэгслээр дэмжих эрх зүйн үндэс бүрдэнэ.

Гуравдугаар бүлэг (Эрүүл мэндийн ажилтанд холбогдох нийтлэг зохицуулалт)-т эрүүл мэндийн ажилтны нийтлэг эрх, үүрэг, нийгмийн баталгааны үндсэн хүрээг тодорхойлж, ажлын онцлог нөхцөлд нийцсэн дэмжлэг, баталгааг цогцоор нь тусгасан. Үүнд цалин хөлс, урамшуулал, тогтвор суурьшлын дэмжлэг, эрүүл мэндийн үзлэг, амралт, гамшиг болон онцгой нөхцөлд ажилласны нөхөн олговор, хамгаалалт зэрэг харилцаа хамаарна.

Дөрөвдүгээр бүлэг (Эмнэлгийн мэргэжилтэнд холбогдох зохицуулалт) нь хуулийн гол зохицуулалт бөгөөд эмнэлгийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн баталгааг тогтооно. Энэ бүлэгт мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх шалгалт, зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох журам, эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг, мэргэжлийн стандарт, ёс зүйн шаардлага, түүнчлэн төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон тасралтгүй боловсрол, сургалтын тогтолцоог нарийвчлан зохицуулсан. Ингэснээр эмнэлгийн мэргэжилтний ур чадварын баталгаа болон хариуцлагын тодорхой байдал харилцан уялдсан тогтолцоо бүрдэнэ.

Тавдугаар бүлэг (Эмнэлгийн бусад мэргэжилтний эрх зүйн байдал)-т эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих чиг үүрэгтэй боловч эмнэлгийн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлдэггүй бусад ажилтны бүртгэл, эрх, үүрэг, мэргэжлийн сахилга, хориглох үйл ажиллагаа, байгууллагын дотоод зохион байгуулалттай уялдах харилцааг зохицуулсан.

Зургаадугаар бүлэг (Эмнэлгийн мэргэжилтний холбоо)-т эмнэлгийн мэргэжилтний өөрөө удирдах байгууллагын эрх зүйн байдал, бүтэц, чиг үүрэг, ил тод байдал, санхүүжилт, гишүүнчлэл, мэргэжлийн ёс зүй, стандарт, тасралтгүй

мэргэжлийн хөгжлийн тогтолцоо, мэргэжлийн сахилга, хариуцлагын дотоод механизмтай холбоотой зохицуулалтыг тусгасан. Энэ бүлгийн зарим зохицуулалтыг шилжилтийн тодорхой хугацаатайгаар хэрэгжүүлэхээр тусгаснаар институцийн болон зохион байгуулалтын бэлтгэлийг хангах боломж бүрдэнэ.

Долоодугаар бүлэг (Мэргэжлийн хариуцлагын даатгал)-т эмнэлгийн тусламж, үйлчилгээний явцад учирч болзошгүй эрсдэлийн улмаас үүсэх хохирлыг шуурхай, хохирол багатай барагдуулах зорилгоор мэргэжлийн хариуцлагын даатгалын эрх зүйн тогтолцоог хуульчилсан. Уг тогтолцоо нь нэг талаас өвчтөний эрх, ашиг сонирхлыг хамгаалах, нөгөө талаас эмнэлгийн мэргэжилтнийг зөвшөөрөгдөх эрсдэлийн хүрээнд хамгаалах тэнцвэртэй механизмыг бүрдүүлж, маргааныг удаан хугацааны шүүхийн процессоор бус, эрсдэлийн санхүүжилтийн зохистой арга хэрэгслээр шийдвэрлэх нөхцөлийг хангана.

Наймдугаар бүлэг (Эмнэлгийн маргааныг шийдвэрлэх журам)-т эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой гомдол, маргааныг шүүхийн болон шүүхийн бус журмаар шийдвэрлэх суурь зохицуулалтыг тогтоосон. Үүнд мэргэшсэн дүгнэлт гаргах, эвлэрүүлэн зуучлах, мэргэжлийн хороо, зөвлөлийн оролцоотойгоор маргааныг шийдвэрлэх боломжийг бүрдүүлж, талуудын мэдээлэл авах, өмгөөлүүлэх, нотлох баримт бүрдүүлэх эрхийг хангахын зэрэгцээ эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, алдаанаас суралцах, давтагдахаас сэргийлэх чанарын удирдлагын зорилготой уялдуулсан.

Есдүгээр бүлэг (Бусад зүйл, шилжилтийн зохицуулалт)-т хууль зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага, хуулийн хэрэгжилтийн шилжилтийн үе шат, хууль хүчин төгөлдөр болох хугацаа, түүнчлэн бусад хууль тогтоомжтой уялдуулахтай холбоотой зохицуулалтыг тусгасан.

ДӨРӨВ. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТУРШЛАГА

Эрүүл мэндийн ажилтны эрх зүйн байдлыг бие даасан хууль тогтоомжоор зохицуулах хандлага нь олон улсад түгээмэл бөгөөд энэ нь эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах салшгүй нөхцөл гэж үздэгтэй холбоотой. Олон улсын болон гадаад улсын эрх зүйн зохицуулалтаас харахад эрүүл мэндийн ажилтныг хамгаалах бодлого нь зөвхөн хөдөлмөрийн харилцааны хүрээнд бус, мэргэжлийн үйл ажиллагаа, ёс зүй, хариуцлага, эрсдэлийн удирдлага, маргаан шийдвэрлэх тогтолцоотой нягт уялдсан байдлаар хэрэгжиж байна.

Олон улсын түвшинд Олон улсын хөдөлмөрийн байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас баталсан баримт бичгүүдэд эрүүл мэндийн ажилтныг аюулгүй,

эрүүл орчинд ажиллуулах, зохистой цалин хөлс, нийгмийн хамгаалал, тасралтгүй сургалт, мэргэжлийн хөгжлөөр хангах нь төрийн зайлшгүй үүрэг болохыг онцолдог. Эдгээр баримт бичиг нь эрүүл мэндийн ажилтны хөдөлмөрийн нөхцөл сайжрах нь эцсийн дүндээ иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах эрх бодитоор хэрэгжих үндэс болдгийг тодорхой харуулж байна. Иймд олон улсад эрүүл мэндийн ажилтны эрх, баталгааг салбарын чанар, аюулгүй байдлын бодлогын салшгүй хэсэг болгон авч үздэг нийтлэг чиг хандлага тогтжээ.

Гадаад улс орнуудын туршлагаас үзэхэд эрүүл мэндийн ажилтны мэргэжлийн үйл ажиллагааг зохицуулахдаа гурван үндсэн тулгуур тогтолцоог харилцан уялдуулан хөгжүүлдэг байна. Нэгдүгээрт, мэргэжлийн өөрөө удирдах байгууллагаар дамжуулан мэргэжлийн стандарт, ёс зүй, сахилга хариуцлагыг хэрэгжүүлэх тогтолцоо түгээмэл байна. Германд эмч нарын танхим, Их Британид Эмнэлгийн ерөнхий зөвлөл, Австралид үндэсний бүртгэл, магадлан итгэмжлэлийн тогтолцоо нь эмнэлгийн мэргэжилтний ур чадвар, ёс зүй, тасралтгүй хөгжлийг хянах, дэмжихэд гол үүрэг гүйцэтгэж байна. Энэ нь мэргэжлийн хяналтыг зөвхөн төрийн байгууллагын хүрээнд бус, мэргэжлийн хамтын хариуцлагад тулгуурлан хэрэгжүүлэх боломжийг олгож, олон нийтийн итгэлийг хадгалах чухал хэрэгсэл болдог.

Хоёрдугаарт, эмнэлгийн тусламж, үйлчилгээний явцад учирч болзошгүй эрсдэлийг зөвхөн эрүүгийн болон иргэний хариуцлагын хүрээнд бус, санхүүгийн эрсдэлийн удирдлагын тогтолцоогоор зохицуулах хандлага давамгайлж байна. Япон, Канад зэрэг улсад эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжлийн хариуцлагын даатгал, хамгаалалтын сан, хууль зүйн туслалцааны механизмаар хамгаалж, нэгэн зэрэг өвчтөнд учирсан хохирлыг богино хугацаанд барагдуулах тогтолцоо бүрдсэн байдаг. Харин Шинэ Зеланд зэрэг улсад эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой гэм хорыг “үл буруутгах” зарчимд суурилсан нөхөн төлбөрийн тогтолцоогоор шийдвэрлэж, шүүхийн маргааныг эрс бууруулсан туршлага байна. Эдгээр жишээ нь эмнэлгийн мэргэжилтний үйл ажиллагаанд зайлшгүй дагалддаг эрсдэлийг “шийтгэх” бус, “удирдах” бодлогоор зохицуулах нь салбарын тогтвортой байдалд эерэг нөлөөтэйг харуулж байна.

Гуравдугаарт, эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой маргааныг шүүхийн бус, мэргэшсэн журмаар шийдвэрлэх тогтолцоо өргөн хөгжсөн байна. Их Британи, Япон зэрэг улсад эмнэлгийн маргаанд мэргэжлийн дүгнэлт, эвлэрүүлэн зуучлал, тусгайлсан зөвлөл, байгууллага оролцуулах замаар маргааныг эрт үе шатанд шийдвэрлэж, талуудын зардал, цаг хугацааны алдагдлыг багасгах, улмаар алдаанаас суралцах, дахин давтагдахаас сэргийлэхэд чиглэсэн чанарын удирдлагын

тогтолцоотой уялдуулан хэрэгжүүлдэг. Энэ нь маргааныг зөвхөн “шийдвэрлэх” бус, салбарын чанарыг сайжруулах хэрэгсэл болгон ашиглаж байгаагаараа онцлог юм.

Дээрх олон улсын болон гадаад улсын туршлагыг нэгтгэн дүгнэвэл эрүүл мэндийн ажилтны эрх зүйн зохицуулалт нь мэргэжлийн өөрөө удирдах байгууллага, мэргэжлийн хариуцлагын даатгал, эмнэлгийн маргаан шийдвэрлэх тусгай механизм гэсэн харилцан уялдсан тогтолцоонд суурилж байж бодит үр нөлөө үзүүлдэг нь харагдаж байна. Энэ нь эрүүл мэндийн ажилтныг хамгаалахын зэрэгцээ иргэн, үйлчлүүлэгчийн эрх, ашиг сонирхлыг тэнцвэртэй хангах, улмаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг тогтвортой сайжруулах үндсэн нөхцөл болдог.

Энэхүү хуулийн төслийн зургаа, долоо, наймдугаар бүлэгт тусгасан эмнэлгийн мэргэжилтний холбоо, мэргэжлийн хариуцлагын даатгал, эмнэлгийн маргааныг шийдвэрлэх журамтай холбоотой зохицуулалт нь дээрх олон улсын нийтлэг чиг хандлагатай нийцэж, Монгол Улсын нөхцөлд тохируулан хэрэгжүүлэхээр тусгагдсан болно. Иймд хуулийн төсөл нь гадаад улсын туршлагыг шууд хуулбарлах бус, тэдгээрийн суурь үзэл санаа, институцийн логикийг үндэсний онцлог, эрх зүйн тогтолцоотой уялдуулан нэвтрүүлэхэд чиглэсэн.

ТАВ. ҮНДСЭН ХУУЛЬ БОЛОН БУСАД ХУУЛЬ ТОГТООМЖИЙН УЯЛДАА, ДАГАЛДАХ ӨӨРЧЛӨЛТ

Энэхүү хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний хөдөлмөрлөх эрх, аюулгүй, эрүүл орчинд ажиллах эрх, нийгмийн хамгаалалд хамрагдах эрх, хүний нэр төр, алдар хүндийг хамгаалах үндсэн зарчим, түүнчлэн иргэн эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрхийн бодит хэрэгжилтийг хангахад чиглэсэн зохицуулалтыг тусгасан бөгөөд Үндсэн хуулийн үзэл санаа, суурь зарчимтай бүрэн нийцнэ. Түүнчлэн эрүүл мэндийн ажилтны эрх зүйн байдлыг бие даасан байдлаар тодорхойлж, тэдний мэргэжлийн үйл ажиллагааг хамгаалах, нийгмийн баталгааг хангах замаар Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг салбарын онцлогт тохируулан бодитой хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэхэд энэхүү хуулийн төсөл чиглэсэн.

Хуулийн төслийг баталсантай холбогдуулан эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй бусад хууль тогтоомжтой уялдуулан зохицуулалтыг нийцүүлэх, зарим харилцааг нарийвчлах, давхардал, хийдлийг арилгах хууль зүйн хэрэгцээ үүснэ. Тухайлбал, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд эрүүл мэндийн ажилтны эрх зүйн байдал, хүний нөөцийн удирдлага, мэргэжлийн стандарт, чанар, аюулгүй байдал, эрсдэлийн удирдлага, мэргэжлийн хариуцлагын даатгалтай

холбоотой зохицуулалтыг нийцүүлэх шаардлагатай болно. Эдгээр өөрчлөлт нь салбарын хууль тогтоомжийн уялдаа холбоог сайжруулж, эрх зүйн зохицуулалтыг цогц, ойлгомжтой болгоход чиглэнэ.

Мөн эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой маргаан, хариуцлагын асуудлыг зохистой, тэнцвэртэй шийдвэрлэх зорилгоор Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах, шаардлагатай тохиолдолд Эрүүгийн хууль болон холбогдох процессын хууль тогтоомжид мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд гарсан алдаа, эрсдэл, санаатай үйлдлийг ялган тодорхойлох, мэргэшсэн дүгнэлтийн ач холбогдлыг нэмэгдүүлэх, шүүхийн бус шатны зохицуулалтыг тодорхой болгох хууль зүйн зохицуулалт хийх хэрэгцээ бий болно. Энэ нь эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагааг үндэслэлгүйгээр эрүүгийн хариуцлагад татах эрсдэлийг бууруулахын зэрэгцээ иргэн, үйлчлүүлэгчийн эрхийг хамгаалах тэнцвэртэй орчинг бүрдүүлэх ач холбогдолтой.

Түүнчлэн хуулийг бодитой хэрэгжүүлэхийн тулд мэргэжлийн хариуцлагын даатгал, эмнэлгийн мэргэжилтний холбоо, тасралтгүй мэргэжлийн хөгжлийн тогтолцоо, эмнэлгийн маргаан шийдвэрлэх журамтай холбоотой дагалдах журам, стандарт, заавар, сургалтын шаардлага, мэргэшлийн шалгуур, даатгалын нөхцөл, шалгуур зэрэг хэрэгжилтийн баримт бичгүүдийг үе шаттайгаар боловсруулж, батлах шаардлага үүснэ. Эдгээр баримт бичгийг хуулийн хүчин төгөлдөр болохоос өмнө болон хэрэгжилтийн явцад уялдуулан боловсруулж, хэрэгжүүлэх нь хуулийн хэрэгжилтийг тасралтгүй, жигд, ойлгомжтой хангах үндсэн нөхцөл болно.

Дээрх уялдаа холбоо, дагалдах өөрчлөлтийг цогцоор нь авч хэрэгжүүлснээр “Эрүүл мэндийн ажилтны тухай” хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон салбарын бусад хууль тогтоомжтой нийцэн хэрэгжиж, эрүүл мэндийн салбарын эрх зүйн зохицуулалтын тогтвортой байдал, хуулийн зорилго, хэрэгжилтийн бодит үр нөлөөг бүрэн хангах боломж бүрдэнэ.